



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/93/НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|-------------------------------------|
| 1. Аудитын санал дүгнэлт..... | Error! Bookmark not defined. |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5 |
| 3. Аудитын тайлан..... | 12 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 12 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 13 |
| 3.4 Материаллаг байдал | 13 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 13 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 14 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 15 |
| 3.8 Аудитын гол асуудал | 15 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 16 |
| 4. Аудитын илрүүлэлт | 16 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 18 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 127
танай _____ ны № _____ т

Г ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ Г
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН Г
ЗАХИРАЛ Ж.АРИУНАА ТАНАА

Г Зөрчилгүй дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020760

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4foot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>134,379,658.69</u> | <u>132,757,070.33</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 4,470,700.00 | 2,739,300.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 4,470,700.00 | 2,739,300.00 |
| 3121 | Төгрөг | 4,470,700.00 | 2,739,300.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 4,470,700.00 | 2,739,300.00 |
| 33 | АВЛАГА | 10,664,540.90 | 29,596,497.98 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 11,230,220.43 |
| 335 | Бусад авлага | 10,664,540.90 | 18,366,277.55 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 10,390,930.90 | 14,366,277.55 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 273,610.00 | 4,000,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 119,244,417.79 | 100,421,272.35 |
| 354 | Хангамжийн материал | 119,244,417.79 | 100,421,272.35 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,482,860.00 | 5,810,660.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 44,347,555.45 | 44,334,610.45 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,864,780.00 | 41,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,921,800.00 | 253,999.99 |
| 35460 | Хүнсний материал | 11,688,370.43 | 42,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 48,939,051.91 | 49,939,001.91 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>2,763,720,725.45</u> | <u>2,793,655,499.35</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,763,720,725.45 | 2,793,655,499.35 |
| 392 | Биет хөрөнгө | 2,704,378,058.77 | 2,734,428,332.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,568,249,784.41 | 5,745,344,958.41 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -3,126,923,493.01 | -3,318,865,650.13 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 00.00 | 42,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -1,180,555.56 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 214,754,225.36 | 259,136,878.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -110,110,631.84 | -140,163,641.06 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 145,585,143.27 | 153,581,149.38 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37,504,272.47 | -58,804,849.93 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 54,226,151.83 | 60,086,014.83 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -26,301,821.43 | -34,053,188.03 |
| 39217 | Ном | 22,402,972.65 | 26,847,216.20 |
| 393 | Биет бус хөрөнгө | 59,342,666.68 | 59,227,166.68 |
| 39301 | Програм хангамж | 1,155,000.00 | 1,155,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -106,333.32 | -221,833.32 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 58,294,000.00 | 58,294,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>2,898,100,384.14</u> | <u>2,926,412,569.68</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>00.00</u> | <u>561,000.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 561,000.00 |
| 413 | Өглөг | 00.00 | 561,000.00 |

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|------------|---|-------------------------|-------------------------|
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 561,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,898,100,384.14 | 2,925,851,569.68 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,898,100,384.14 | 2,925,851,569.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 981,093,711.45 | 981,093,711.45 |
| 51101 | Өмч: - төрийн | 981,093,711.45 | 981,093,711.45 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 517,155,783.37 | 544,906,968.91 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 517,155,783.37 | 517,155,783.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 27,751,185.54 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,399,850,889.32 | 1,399,850,889.32 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,898,100,384.14 | 2,926,412,569.68 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,849,785,284.07 | 1,888,467,426.11 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,254,476,884.07 | 236,419,594.11 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,254,476,884.07 | 236,419,594.11 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 64,804,889.98 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө | 64,804,889.98 | 227,504,894.11 |
| 120009 | Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал | 00.00 | 8,914,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,595,308,400.00 | 1,652,047,832.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,298,393,500.00 | 1,214,278,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,292,593,500.00 | 1,214,278,500.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 5,800,000.00 | 00.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 521,000.00 | 48,936,318.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 8,966,318.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 21,000.00 | 39,970,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 296,393,900.00 | 388,833,014.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 296,393,900.00 | 388,833,014.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,832,587,608.64 | 1,855,687,961.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,832,587,608.64 | 1,855,687,961.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,676,017,472.27 | 1,814,459,525.15 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 915,149,407.13 | 942,534,592.10 |
| 210101 | Үндсэн цалин | 608,396,350.50 | 608,616,684.35 |
| 210102 | Нэмэгдэл | 239,835,283.63 | 265,493,284.79 |
| 210104 | Урамшуулал | 66,917,773.00 | 68,424,622.96 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 113,947,132.00 | 123,509,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 82,179,195.00 | 86,979,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,674,650.00 | 8,973,700.00 |

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-------------------------|-----------------------|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,607,950.00 | 7,398,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,066,700.00 | 1,821,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,418,637.00 | 18,336,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 294,872,721.00 | 389,239,814.01 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,965,687.00 | 10,191,294.00 |
| 210302 | Түлш, халаалт | 282,980,868.00 | 370,548,520.01 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,926,166.00 | 8,500,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,903,136.00 | 12,511,025.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,333,446.00 | 2,210,330.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,950,000.00 | 3,697,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 580,300.00 | 147,475.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 53,000.00 | 64,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,971,090.00 | 3,104,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,015,300.00 | 3,287,120.00 |
| 2105 | Нормативт зардал | 50,879,865.00 | 63,614,570.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 180,000.00 | 1,067,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 48,688,605.00 | 60,230,470.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,011,260.00 | 2,316,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,536,500.00 | 8,690,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,536,500.00 | 8,690,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 837,100.00 | 614,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 837,100.00 | 614,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,528,200.00 | 1,153,760.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,528,200.00 | 1,153,760.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 287,363,411.14 | 272,591,764.04 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,329,300.00 | 12,463,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,785,684.00 | 3,526,618.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 284,248,427.14 | 256,601,396.04 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 156,570,136.37 | 41,228,436.25 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 23,249,477.40 | 39,016,260.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,649,477.40 | 38,216,260.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.00 | 800,000.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 133,320,658.97 | 2,206,176.25 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 133,320,658.97 | 2,206,176.25 |
| | Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт | | 6,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,017,197,675.43 | 32,779,464.71 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 29,569,375.09 | 5,028,279.17 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 29,569,375.09 | 5,028,279.17 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -29,569,375.09 | -5,028,279.17 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 987,628,300.34 | 27,751,185.54 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 922,799,711.45 | 898,564,736.05 | -348,515,833.19 | 1,472,848,614.31 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 922,799,711.45 | 898,564,736.05 | -348,515,833.19 | 1,472,848,614.31 |

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|-----|--|-----------------------|-------------------------|-----------------------|-------------------------|
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 501,286,153.27 | 00.00 | 501,286,153.27 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 58,294,000.00 | 00.00 | 00.00 | 58,294,000.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 114,230,647.79 | 114,230,647.79 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 981,093,711.45 | 1,399,850,889.32 | 517,155,783.37 | 2,898,100,384.14 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 981,093,711.45 | 1,399,850,889.32 | 517,155,783.37 | 2,898,100,384.14 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 981,093,711.45 | 1,399,850,889.32 | 517,155,783.37 | 2,898,100,384.14 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 27,751,185.54 | 27,751,185.54 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 981,093,711.45 | 1,399,850,889.32 | 544,906,968.91 | 2,925,851,569.68 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,606,865,440.00 | 1,666,382,652.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 11,557,040.00 | 4,334,820.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 11,557,040.00 | 4,334,820.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,557,040.00 | 4,334,820.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,557,040.00 | 4,334,820.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,595,308,400.00 | 1,662,047,832.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,298,393,500.00 | 1,214,278,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,292,593,500.00 | 1,214,278,500.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 5,800,000.00 | 00.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 521,000.00 | 58,936,318.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 8,966,318.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 21,000.00 | 49,970,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 296,393,900.00 | 388,833,014.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 296,393,900.00 | 388,833,014.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,581,018,540.00 | 1,604,680,992.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,581,018,540.00 | 1,604,680,992.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,414,283,481.03 | 1,566,827,215.75 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 915,540,338.03 | 942,773,898.75 |
| 210101 | Үндсэн цалин | 583,668,250.00 | 615,202,476.12 |
| 210102 | Нэмэгдэл | 264,954,315.03 | 259,146,799.67 |
| 210104 | Урамшуулал | 66,917,773.00 | 68,424,622.96 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 113,947,132.00 | 123,509,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 82,179,195.00 | 86,837,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,674,650.00 | 9,116,200.00 |

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,607,950.00 | 7,386,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,066,700.00 | 1,833,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,418,637.00 | 18,336,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 294,572,521.00 | 387,692,014.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,965,687.00 | 10,191,294.00 |
| 210302 | Түлш, халаалт | 282,680,668.00 | 369,000,720.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,926,166.00 | 8,500,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,216,890.00 | 10,622,623.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 639,000.00 | 1,751,418.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,950,000.00 | 2,652,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 580,300.00 | 461,655.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 194,900.00 | 501,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,570,000.00 | 2,848,650.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,282,690.00 | 2,407,400.00 |
| 2105 | Нормативт зардал | 60,824,800.00 | 67,819,850.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 481,400.00 | 784,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 57,586,900.00 | 64,481,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,756,500.00 | 2,553,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,480,200.00 | 14,700,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 13,000,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,480,200.00 | 1,700,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 837,100.00 | 614,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 837,100.00 | 614,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,450,200.00 | 1,440,560.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,450,200.00 | 1,440,560.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,414,300.00 | 17,654,470.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,329,300.00 | 12,532,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,085,000.00 | 5,121,570.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 166,735,058.97 | 37,853,776.25 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 33,414,400.00 | 35,641,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,814,400.00 | 34,841,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.00 | 800,000.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 133,320,658.97 | 2,206,176.25 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 133,320,658.97 | 2,206,176.25 |
| | | | 6,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 25,846,900.00 | 61,701,660.00 |
| 140008 | Хүлээн авсан ногдол ашиг | 00.00 | 00.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 21,376,200.00 | 63,433,060.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 21,376,200.00 | 63,433,060.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 21,376,200.00 | 63,433,060.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 19,860,000.00 | 17,369,200.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,516,200.00 | 46,063,860.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -21,376,200.00 | -63,433,060.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |

| | | | |
|----|--|--------------|---------------|
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 4,470,700.00 | -1,731,400.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 4,470,700.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4,470,700.00 | 2,739,300.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,606,451,900.00 | 1,605,240,157.75 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,570,750,300.00 | 1,569,598,557.75 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,570,750,300.00 | 1,569,598,557.75 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 942,879,100.00 | 942,773,898.75 |
| 210101 | Үндсэн цалин | 615,366,200.00 | 615,202,476.12 |
| 210102 | Нэмэгдэл | 255,712,100.00 | 259,146,799.67 |
| 210104 | Урамшуулал | 71,800,800.00 | 68,424,622.96 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 123,509,800.00 | 123,509,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,837,400.00 | 86,837,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,116,200.00 | 9,116,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,386,300.00 | 7,386,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,833,700.00 | 1,833,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,336,200.00 | 18,336,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 388,738,400.00 | 387,692,014.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,220,000.00 | 10,191,294.00 |
| 210302 | Түлш, халаалт | 369,018,400.00 | 369,000,720.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,500,000.00 | 8,500,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 00.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,743,900.00 | 12,743,855.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,772,100.00 | 1,772,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,652,300.00 | 2,652,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 706,800.00 | 467,655.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 729,200.00 | 881,550.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,257,200.00 | 2,372,650.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,626,300.00 | 4,597,600.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 00.00 |
| 2105 | Нормативт зардал | 67,823,400.00 | 67,823,350.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 784,900.00 | 784,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 64,481,500.00 | 64,481,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,557,000.00 | 2,557,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,700,000.00 | 22,700,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,000,000.00 | 21,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,700,000.00 | 1,700,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 614,000.00 | 614,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 614,000.00 | 614,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 445,100.00 | 445,060.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 445,100.00 | 445,060.00 |

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|---------------|--|------------------|------------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11296600.00 | 11296580.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,387,500.00 | 3,387,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,909,100.00 | 7,909,080.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35701600.00 | 35641600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 35,701,600.00 | 35,641,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 34,901,600.00 | 34,841,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 800,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 00.00 | 1,607,446,334.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 00.00 | 1,214,278,500.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,216,013,500.00 | 1,214,278,500.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 00.00 | 388,833,014.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 390,438,400.00 | 388,833,014.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 00.00 | 4,334,820.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 4,334,820.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 4,470,700.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 2,739,300.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 00.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 00.00 | 00.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 76.00 | 76.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 54.00 | 54.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 21.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 887.00 | 887.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 53.00 | 53.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 23.00 | 23.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл / төгрөгөөр / |
|-------------|--|----------|-------------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 00.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 58,930,318.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 966,318.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 490,318.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 476,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 8,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 8,000,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 49964000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 49,964,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 58936318.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 58,936,318.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 8,966,318.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 49,970,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг хангах, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд дараах зорилтыг тавин ажиллажээ.

- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж ажиллана.
- Суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахууд суралцах боломж олгох, тэдний авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах бодлого баримтлан ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.
- Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим агуулга, цахим хичээл боловсруулж, бүх насны иргэдийн “Насан туршийн боловсрол”-ыг дэмжинэ.
- Багшлах боловсон хүчний мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгож, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд анхаарна

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нөлөөгүй байна.

Дотоод хяналтын 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байдаг ч хяналт шалгалт хийгээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 1862.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 27.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 20.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62.4 сая төгрөгөөр өссөн нь авлага, үндсэн хөрөнгө, бараа материал өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /Мян.төг / |
|---|---------------------|---------------------|------------------|
| | | | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 4470.7 | 2739.3 | -1731.4 |
| Авлага | 10664.5409 | 29596.49798 | 18,931.96 |
| Бараа материал | 119244.4178 | 100421.2724 | -18,823.15 |
| Үндсэн хөрөнгө | 2,763,720.73 | 2,793,655.50 | 29,934.77 |
| Нийт хөрөнгө | 2,898,100.38 | 2,926,412.57 | 28,312.19 |
| Өглөг | 0 | 561 | 561 |
| Хуримтлагдсан үр дүн | 517,155.78 | 544,906.97 | 27,751.19 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 2,898,100.38 | 2,926,412.57 | 28,312.19 |

Авлага: Тайлант онд шинээр 18.9 сая төгрөгийн авлага үүссэн нь оны эцэст төсөвт зохицуулалт хийснээр цахим самбар, математик танхим тохижуулах хөрөнгө худалдан авах гэрээг хийж 2022 оны 01 дүгээр сарын 31-нд бараа нийлүүлэхээр гэрээнд тусгаж санхүүжилтийг олгосноор авлага үүссэн байна.

Бараа материал: Бараа материалын оны эхний үлдэгдэл 119.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 100.4 сая төгрөг болж өмнөх оноос 18.8 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 130.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 121.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 8.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

Нийт 149.2 сая төгрөгийн бараа материал хасагдсанаас 133.1 сая төгрөг зарцуулж, цар тахалтай холбоотой хүнсний үлдэгдэл 3.1, түлшний үлдэгдэл 1.1 нийт 4.2 сая төгрөгийн материал худалдаж, 11.2 сая төгрөгийн хүнс дутагдуулж эд хариуцагчаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож авлага үүсгэсэн, 0.6 сая төгрөгийн материал акталж тус тус хассан байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 6064.7 сая, эцсийн үлдэгдэл 6346.9 сая төгрөг болж өмнөх оноос 282.2 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 63.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсний 42.5 сая төгрөг нь хандив цуглуулж нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авто машин авсан, 227.5 сая төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгийн 177.1 сая төгрөг нь барилга орлогод авахад дутуу үнийн дүнгээр орлогодсоныг тайлант онд нэмж авсан, тушаалаар 8.6 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр: Өр төлбөр данс эхний үлдэгдэлгүй тайлант онд ажилчдаас илүү суутгасан 0.6 сая төгрөгийг өглөгөөр тусгаж тайлагнасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 5 арга хэмжээнд зориулан 1606.5 сая төгрөгийн төсөв баталснаас 1216.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 390.4 төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1214.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 388.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, 1605.2 сая төгрөгийг зарцуулж 2.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1605.2 сая төгрөг буюу 99.9 хувьтай буюу бүрэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 58.9 сая төгрөгийн орлого бүрдсэний 0.5 сая төгрөг нь БШУЯ-ны сайдын 2021 оны 08 сарын 12-ны А/279 Ковид-19 цар тархалтын үед хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан ариутгалд зориулан, мөн 2015 оноос Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд “Эх хэл эрдмийн түлхүүр” төсөл бичиж 8.0, Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2021.07.09 А/60 тоот тушаалаар сурагчдын мэдлэг, чадварын ялгаатай байдлыг оношлох, үнэлгээг зохион байгуулах үйл ажиллагааны бичиг хэргийн зардалд 0.5 сая төгрөг санхүүжилтийг авсан байна. Сурагчдын автобус худалдан авахад зориулан хандив 49.9 сая төгрөгийн орлогоор бүртгэж, төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын бүрэн зарцуулсан хэмнэлт гаргаж ажиллаагүй,
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт хэмнэлт гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроосон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлаас 20933060 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 13000000 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна.
- Тайлант онд байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой дотоод хяналт шалгалтыг зохион байгууллаагүй, дотоод хяналт сул байгаатай холбоотой зөрчил дутагдал

илэрч байна. ЗГ-ын 2011 оны 311 тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-тай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 38967.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, мянган төгрөгийн алдааг залруулж, 1526.2 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 862.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 36579.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч хэрэгжилт хангагдсан байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Байгууллагын дотоод хяналт, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3678.0 сая төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс, 3627.1 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 15.4 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 33.9 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага өгч, 1.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

- Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн буюу тодруулга, тэмдэглэл бэлтгэж гаргаагүй, эргэлтийн хөрөнгөд 18,986,154.93, үндсэн хөрөнгийн тайланд -169,748,342.03, үр дүнгийн тайланд 3,583,747,131.66 төгрөгийн залруулга хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна: 8.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан заавар, журамтай нийцээгүй НББ-ийн тухай хуулийн 15.1-д заасны дагуу залруулга хийсэн.
- Хүнсний материал дутагдуулсан 11.2, хөрөнгө худалдан авах гэрээ байгуулж 13.0 төгрөгийн санхүүжилт олгож авлага үүснийг санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйг аудитын явцад залруулсан.
- Ажилтны цалингаас илүү суутгасан 0.6 төгрөгийг өглөгөөр тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", "14.4.3.бүх өр төлбөр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйг аудитын явцад залруулж өглөгөөр бүртгэсэн.

4.2 Төлбөрийн акт

- Хоол, хүнсний зардлаас анхан шатны баримтгүй 120000 төгрөгийг зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтуудыг зөрчсөн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Эд хариуцагч мах худалдан авахаар 1000000 төгрөгийг шилжүүлж авлагаар бүртгэсэн боловч материал хүлээн аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ”, гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй авлага барагдуулаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

- Завсарын аудитаар хүнсний материал дутагдуулсан 11202890, мах худалдан авахаар 3000000 төгрөг олгосон боловч материал хүлээн аваагүй, цахим ангид худалдан авсан тоног төхөөрөмжөөс 4 ширхэг 6000000 төгрөгийн проектор хүлээн аваагүй нийт 20202890 төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлаас 20933060 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 13000000 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд албан шаардлага өглөө.
- Шилэн дансны цахим хуудсанд 15 мэдээллийг хугацаа хоцроосон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага өглөө.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: И-баримтаас түүвэр хийхэд 12203460 төгрөгийн баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно;", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна

1.2. Өгсөн зөвлөмж: Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг хэрэгжүүлэх.

2. Дотоод хяналттай холбоотой

3.1 Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой дотоод хяналт шалгалтыг зохион байгуулаагүй, дотоод хяналт сул байгаатай холбоотой зөрчил дутагдал илэрч байна.

Энэ нь ЗГ-ын 2011 оны 311 тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, хөрөнгийн хадгалалт хамгаалтанд тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------|--------|-----------|--------|------------------|------|--------------------|------|---------|-----|
| | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | 10 | 3678.0 | 3 | 3627.1 | 3 | 15.4 | 2 | 33.9 | 2 | 1.6 |
| Дүн | | | | | | | | | | |